

	тэмцэх нийгэмлэг; • Төгс бүсгүйчүүд ТББ; • Залуус эрүүл мэнд ТББ Асуулт, хариулт																			
Хөтөлбөр #5	Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ/ДОХ-ын олон орны хамтарсан төслийн эхийг танилцуулах Асуулт, хариулт	x											x							x

Хөтөлбөр тус бүрээр хийсэн тэмдэглэл

Хөтөлбөр #1 Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх(тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Мягмар: ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар хурлыг даргалан хурлын хөтөлбөрийг гишүүдэд танилцуулж, гишүүд саналгүй тул хөтөлбөрийг батлав.
 78 дах хурлын шийдвэрийн биелэлтийг **ҮЗЗ-ийн ажлын албанаас Л.Номин-Эрдэнэ** танилцуулав.

ХУРАЛ 2018 ОНЫ 6 САРЫН 8-НД БОЛСОН

хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	Гүйцэтгэл
хөтөлбөр#2	ҮЗЗ-ийн гишүүдийн саналаар ЭМС-ын 126-р тушаалыг хэрэгжүүлэх үүднээс ҮХА шаардлага, журмын дагуу дахин төлөвлөлтийн асуудлыг боловсруулан, санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгоод хэлэлцүүлэх саналыг ҮЗЗ-ийн Ажлын албанд ирүүлэн ҮЗЗ-ийн хурлыг дахин товлон зарлуулах хүсэлт гаргавал зөвшөөрч болно гэж шийдвэрлэв.	ҮХА-ЭМЯ, ХЗН	70%
хөтөлбөр#4	ҮЗЗ-ийн хуралд хүрэлцэн ирсэн нийт 14 гишүүдийн саналаар ҮЗЗ-ийн дарга, дэд дарга болон гүйцэтгэх, хяналтын, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах хороодын бүтэц бүрэлдэхүүнийг хэлэлцэн, нийт гишүүд гараа өргөн баталлаа. Түүнчлэн ҮЗЗ-ийн Ажлын албанд дүрмийг өөрчлөн баталсантай холбогдуулан шаардлагатай салбар, байгууллагууд руу гишүүдийг томилуулах албан бичгийг хүргүүлэхийг үүрэг болгов.	ҮЗЗ-ийн Ажлын алба	100%

Хөтөлбөр #2 ҮЗЗ-д сонгогдсон шинэ гишүүдийн танилцуулга

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

ҮЗЗ-д сонгогдсон шинэ гишүүдийн танилцуулга ҮЗЗ-ийн нийт гишүүд, хамтран ажиллагсад босч өөрсдийгөө танилцууллаа.

№	Гишүүний нэр	Албан тушаал	Төлөөлөл (салбар)	Сонгогдсон хугацаа
---	--------------	--------------	-------------------	--------------------

1.	У.Бямбасүрэн	ЗГ-ын Хэрэг Эрхлэх Газрын Дэд Дарга	МУ-ын ЗГ-ын Хэрэг Эрхлэх Газрын төлөөлөл	2017-02-23
	Б.Хонгорзул	ЗГ-ын Хэрэг Эрхлэх Газар		
2.	Б.Цогтбаатар	Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ҮЗЗ-ийн Дэд Дарга	Эрүүл Мэндийн Асуудал Эрхэлсэн Төрийн Захиргааны Төв байгууллага	2018-05-31
3.	Т.Энхзаяа	Нийгмийн эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч		2018-05-31
4.	Ж.Мөнхжаргал	Төрийн байгууллагын төлөөлөл	Төрийн байгууллагын төлөөлөл	2018-01
5.	М.Эрдэнэжаргал	НЗДТГ-ын Нийгмийн Бодлогын Хэлтсийн Дарга	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын төлөөлөл	2017-02-22
	М.Зэндмаа	Нийслэлийн ЭМГ-ын орлогч Дарга		2017-02-22
6.	Д.Ангармөрөн	АШИУС-ын шинжлэх ухаан, технологийн газрын дарга	Шинжлэх Ухаан, Боловсролын салбарын төлөөлөл	2018-06-20
7.	Р.Оюунгэрэл	АШИУС-ын АУС-ийн Халдварт өвчин судлалын тэнхимийн эрхлэгч	Шинжлэх Ухаан, Боловсролын салбарын төлөөлөл	2018-06-20
8.	Ц.Даваасүрэн	Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нэгдсэн Холбоо	Сүрьеэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл	2018-07-25
9.	Б.Сувд	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв	ХДХВ, ДОХ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл	2018-10-05
	Э.Эрдэнэцэцэг	Гүнж төв		
10.	С.Дондов	Иргэдэд туслах хүний эрхийн төвийн тэргүүн	Хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл	2018-01-19
	Ч.Сэмжидмаа	Сэтгэлзүйн Мэдрэмж ТББ-ийн тэргүүн		
11.	А.Нямдорж	Залуучуудын Эвсэл	Хүүхдийн эсхүл залуучуудын төрийн бус байгууллагын төлөөлөл	2016-01-29
	Г.Чинзориг			
12.	Б.Мягмар	МҮЭ, Монголын Эрүүл Мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга-ҮЗЗ-ийн Дарга	Хөдөлмөр нийгмийн түншлэгч байгууллага	2014-11-10 2016-11-20
13.	Х.Ганбаатар	Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо	Хувийн хэвшлийн төлөөлөл	2018-08-03
	Э.Энхжаргал			
14.	Ц.Пүрэвжав	N/a	Олон нийтийн төлөөлөл	2018-09-07
	Т.Энхжаргал			
15.	Н.Туяацэцэг	ХУД, 12-р хороо	Олон нийтийн төлөөлөл	2018-08-29
16.	Ж.Одгарьд	Монголын Бурхан Шашинтны төв Гандантэгчэнлин хийд, ОНХАлбаны Дарга	Шашны байгууллага	2016-09-25
	Ч.Бямбажаргал			
17.	Ц.Адъяахишиг	ХЭҮК-ын Ахлах референт	Хүний Эрхийн Үндэсний Комисс	2017-02-03
	Г.Золзаяа	ХЭҮК-ын Референт		

18.	А.Цэцэгмаа	Мэргэжилтэн	НҮБ-ын Суурин Зохицуулагчийн Газар	2017-06-23
19.	Др.Сергей Диордица	ДЭМБ, Суурин төлөөлөгч	Олон Улсын Байгууллага	2017-10-17
	Ж.Нарантуяа	ДЭМБ-ын мэргэжилтэн		
20.	Г.Нямпүрэв	Залуус Эрүүл Мэнд ТББ	Эрсдэлт Бүлгийн Төлөөлөл	2018-01-16
	Э.Сод-Эрдэнэ			
21.	Б.Баярмаа	Төгс Бүсгүйчүүд	Эрсдэлт Бүлгийн Төлөөлөл	2018-09-13
	<i>С.Энхжин</i>	<i>ҮЗЗ Хяналтын хорооны гишүүн</i>	<i>ЭМЯ, ХШУДАГ</i>	<i>2018-06-20</i>

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		
		Эсрэг>		
			Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #3

Глобаль Сангийн багийнхны танилцуулга

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Аллан Нфамба, ГС-гийн МУ-ыг хариуцсан менежер: Хүрэлцэн ирсэн нийт хамтран ажиллагсаддаа талархал илэрхийлье. Энд ирж та бүхэнтэй танилцаж хамтран ажиллах нь таатай байлаа. Энд хүрэлцэн ирж бид мэдлэг мэдээлэлтэй болж хэрхэн ажиллах талаар ойлголт авч цаашид хэрхэн туслахаа төлөвлөх бололцоотой болсон гэж харж байна. Ингээд нээлтийн үгийг хэлнэ үү гэж ГС-гийн бүсийн менежер Лука Очинигоос хүсье.

ГС-гийн бүсийн менежер Лука Очини: Би та бүхэнд монголоор үг хэлэхэийг хүсэж байгаа ч миний монгол хэл маш муу. Энэ миний Монголд хүрэлцэн ирсэн анхны айлчлал бөгөөд энэ завшааныг ашиглан та бүхэнтэй уулзсан нь маш сайхан хэрэг байлаа. Бид энэхүү айлчлалаараа Монголоос 3 чухал зүйлийг олж мэдсэн нь сайн хэрэг болж байна. Үүнд:

1. Засгийн газраас ДОХ, сүрьеэтэй цаашид тэмцэх болно гэдгээ мэдэгдсэн. Энэ нь эдгээр халдварт өвчнүүдтэй тэмцэх улс төрийн амлалт болж байна.
2. Энэ өрөөнд байгаа хүмүүс болон гадна ажиллаж байгаа хүмүүст Техникийн асар их боломж байгааг мэдсэн явдал байсан.
3. Техникийн хамтран ажиллагсад жишээлбэл: ДЭМБ. Та бүхэн тэднээс маш их туслалцаа авах боломжтой бөгөөд яг тухайлсан ДОХ, сүрьеэгийн мэргэжилтнүүдтэй нь хамтран ажиллах боломжтой нь бүсийн бусад орны дэргэд үнэхээр таатай хэрэг юм.

Хэрэв та бүхэн дээрх 3 элементийг нэгтгэн бидэнтэй ажиллавал ДОХ, сүрьеэгийн халдварт өвчнүүдийг арилгах боломжтой. Бид Монгол улстай сүүлийн 15 жилийн турш хамтран ажиллаж байна. Миний бодлоор бид эдгээр өвчнүүдийг зогсоох зохих түвшний хамтын ажиллагаанд хүрсэн гэж харж байна. Бид та бүхэнд асуудлууд тулгарна гэдгийг ойлгож байна. Тиймээс та бүхэн хамтын

ажиллагаагаа сайжруулах хэрэгтэй. Та бүхэнд Алан бидний олж харсан асуудлууд болон сайжруулах боломж бололцооны талаар хэлэх болно. Энэхүү нээлтийн үгийг дуусгахдаа би та бүхэнтэй ийн уулзаж, биеэр харж ярилцсан нь сайн туршлага болж үлдэхийг хэлмээр байна. Түүнчлэн бидний зочлон очсон байгууллагууд нь өндөр ур чадвартай, цаашид хамтран ажиллах боломжтой байгууллагууд байсан гэдгийг дуулгахад таатай байна.

Аллан Нфамба: Та бүхэн Лука Очинигийн хэлсэн эдгээр элементүүд дээр ямар саналтай байна вэ? Бид бүхэн Сүрьеэгийн тохиолдол их байгааг мэдэж байгаагчлан идэвхитэй илрүүлэгийн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх хэрэгтэй. Бид энэ асуудлын хүрээнд ХӨСҮТ-тэй хэлэлцсэн. Түүгээр бид Улаанбаатар хот болон аймгуудад идэвхитэй илрүүлгийн төлөвлөлтүүд хийгдэж байгааг ч мэдсэн. Одоогийн төслийн санхүүжилтын хүрээнд 4 geneXpert, 10 зөөврийн рентген аппарат ханган нийлүүлэгдэнэ. Та бүхэн тэдгээрийг ашиглан идэвхитэй илрүүлгийн төлөвлөгөөний зорилтдоо хүрч ажиллахыг хичээх хэрэгтэй. Боломж гарвал ГС илүү хөрөнгө босгон олон тоног төхөөрөмж авч өгөхийг хичээн ажиллах болно. Та бүхэнд цаг агаарын нөхцөл байдлаас эхлүүлээд олон төрлийн асуудлууд тулгарна гэдгийг ойлгож байна.

ДОХ-ын хувьд Монгол улс 90-90-90 зорилтод тулгуурлан ажилладаг. Сүүлийн 2 90-ийн зорилтод хүрсэн байдал сайн харагдаж байгаа.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Хариулт:

--

Шийдвэр:

--

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		
		Эсрэг>		
			Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #4	<p>Салбар хүлээн авагчийн танилцуулга:</p> <ul style="list-style-type: none"> • Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг; • Төгс бүсгүйчүүд ТББ; • Залуус эрүүл мэнд ТББ
--------------------	---

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (гийм эсвэл үгүй)> үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Салбар хүлээн авагчийн танилцуулга:

- **Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн** талаарх мэдээллийг Б.Солонго танилцууллаа. */Хавсралт 1- МСТН-ийн танилцуулга/*

Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг нь 2003 оноос эхлэн Глобал сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн салбар хүлээн авагч байгууллагаар ажиллаж эхэлсэн.

Үр дүн

- Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт оролцож эхэлсэн анхны санаачлага
- Тухайн сум баг хорооны олон нийтийн дундаас сонгогдсон, тухайн олон нийтийн төлөөлөл учраас зорилтот хүн амд хамгийн сайн хүрч ажилладаг.
- Эмнэлгийн бус мэргэжлийн хүмүүс боловч сайн дураараа энэхүү халдварт өвчнийг бууруулахаар

нэгдэж өнгөрсөн 15 жилийн хугацаанд 31343 сүрьеэтэй өвчтнийг эмчилж эдгэрүүлэхэд хувь нэмэр оруулсан.

- Өдөр бүр эмнэлэг дээр ирж эм уух боломжгүй (хэвтрийн, унааны мөнгөгүй, ажлын цаг таардаггүй, хол амьдардаг, жирэмсэн, нялх хүүхэдтэй гэх мэт) сүрьеэтэй өвчтнүүдэд өдөр бүр эмийг хүргэн өгч харж уулгах үйл ажиллагаа 2005-2017 онуудад 21 аймаг, 9 дүүрэгт хэрэгжсэн бөгөөд 2018-2020 онуудад 8 аймаг, 9 дүүрэгт хэрэгжиж байна.
- Улсын хэмжээнд 200 эрүүл мэндийн сайн дурын ажилтан ажиллаж байна. 2018 оны 06-р сарын байдлаар давхардаагүй тоогоор 7554 сүрьеэтэй өвчтөн хоолтой эмчилгээнд хамрагдаж эдгэрч эмчилгээ дууссан байна.
- Сард диспансерийн хяналтанд байгаа нийт өвчтний 30 орчим хувийг олон нийтэд суурилсан ДОТС эмчилгээнд хамруулж байна. Хоол тэжээлийн дутагдалтай, тодорхой орлогогүй болон орлого багатай, ажилгүй өвчтнүүдэд сард нэг удаа хүнсний тусламж үзүүлдэг. Сар бүр 50 өвчтөнд нэг хүний 15 ам.долларын тусламж өгдөг.

Амжилт

- 2016 оны эхний улирлын байдлаар УБ хот, 21 аймагт ЕБС-ийн сурагчдын дундаас үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Нийт 39 сургууль хамрагдаж 755 үе тэнгийн сургагч хүүхдүүд бэлтгэгдсэн.
- Үе тэнгийн сургагч хүүхдүүдийн мэдээлэл өгсөн сурагч, эцэг эх, багш нарын тоо - 18944
- Үе тэнгийн сургагч бэлтгэх хөтөлбөрт НЭМҮТ-өөс үнэлгээ хийгдсэн.

Саад бэрхшээл

- Төрийн дэмжлэг сул /санхүүжилт, төсөл хөтөлбөрийн тогтвортой байдал, байгууллагын чадавхи
- Салбар дундын болон салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүй /сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг илгээх, хүлээн авах, эмзэг бүлгийн судалгаа гэх мэт
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээний хууль эрх зүйн орчин сайжруулах шаардлагатай. /Албадан эмчилгээ, эмчилгээ тасалж буй тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоо байхгүй
- Орон гэргүй, архины хамааралтай өвчтнүүдийн асуудал байдаг.

- **Төгс бүсгүйчүүд ТББ-ын талаарх мэдээллийг Д.Ням-Өлзий, түс ТББ-ын гүйцэтгэх захирал танилцууллаа. /Хавсралт 2- Төгс бүсгүйчүүд ТББ-ын танилцуулга/**

Эрсдэлт бүлгийн хүн ам болох ЭБҮ-ийн дунд ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх, улмаар тэдний дундах ХДХВ, БЗДХ-ын тархалтыг бууруулах зорилготой ажиллаж байна.

Үр дүн

- 2015-2017 онд “Төгс бүсгүйчүүд” ТББ болон орон нутгийн дэд салбар хүлээн авагч 9 ТББ нь ХДХВ-ийн халдвараас сэргийлэх багц хөтөлбөрт 17,100 эмэгтэй биеэ үнэлэгч, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд 11,200 ЭБҮ-ийг хамруулсан.
- Нийт 63 ЭБҮ-ийг үсчин, гоо сайханч, маникюр, нягтлан, зочид буудлын үйлчилгээний ажилтан зэрэг мэргэжил олгох сургалтанд хамруулж, 19 хүнийг ажлын байранд зуучилсан.
- Санхүүгийн Виница программыг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хэрэглэж эхэлсэн.
- Цагдаагийн байгууллагын удирдах, шийдвэр гаргах түвшний ажилтнууд, албан хаагчдын дунд нөлөөллийн уулзалт зохион байгуулснаар төр, ТББ-ын хамтын ажиллагаа сайжирч, ЭБҮ-дийн талаар эерэг мэдээлэлтэй болж, олон нийтийг СДЗШ-нд зуучлан хамтран ажиллаж байна.
- Хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай ажлын уялдаа холбоо сайжирч, хүчирхийлэлд өртсөн ЭБҮ-дэд зөвлөгөө өгөх, эрхийг хамгаалах нөхцөл бүрдсэн.
- ЭБҮ байрладаг зочид буудал, саун массажны газрын эздэд чиглэсэн ухуулга, нөлөөллийн уулзалт хийснээр үйл ажиллагаанд хамрагдах ЭБҮ-дийн тоо нэмэгдсэн.

Амжилт

- Ази номхон далайн бүсийн ЭБҮ-дийн холбооноос 2016 оны 06 дугаар сарын 20-24-ны өдрүүдэд Мьянмар улсад зохион байгуулагдсан сургалтанд “Төгс бүсгүйчүүд” ТББ-ын 2 хүрч очих ажилтаны зардлыг бүрэн хариуцаж, амжилттай оролцож ирсэн.
- 2017 онд АНДБ-ийн ЭБҮ-ийн холбоо өөрсдийн зардлаар Улаанбаатар хотод ЭБҮ-ийн дунд сургалт зохион байгуулсан.
- Жил ирэх тусам СДЗШ-нд хамрагдаж байгаа ЭБҮ-ийн тоо, эмчилгээний хамрагдалт нэмэгдэж байна.

Саад бэрхшээл

- ЦЕГ-аас “Саун массаж” нэртэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон, хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оноос тодорхой үе шаттайгаар зохион байгуулж байна.
- Баар, саун, массажны газрууд хаагдаж, ЭБҮ-чид байршил тодорхойгүй далд хэлбэрт шилжин үйл ажиллагаанд хамруулахад бэрхшээлтэй байна.
- Биеэ үнэлэгчид цахим орчин ашиглан үйлчлүүлэгчээ олох, харилцаа холбоо тогтоон санхүүгийн дэмжлэг авна гэсэн зарын дагуу биеэ үнэлэх явдал ихсэх хандлагатай байна.
- ЭБҮ-дийн хувьд хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байна.

- **Залуус эрүүл мэнд ТББ талаарх мэдээллийг Д.Мягмардорж, түс ТББ-ын гүйцэтгэх захирал танилцууллаа. /Хавсралт 3- Залуус эрүүл мэнд ТББ-ын танилцуулга/**

ХДХВ-ийн халдвартай оношилогдсон эрэгтэйчүүдийн 80% нь ЭБЭ, ЭБЭ бүлгийн дундах ХДХВ-ийн тархалт 9.2%, Барагцаалсан тоогоор нийт насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 0,4% -д хүрэх зорилт тавин ажиллаж байна.

Үр дүн

- Бэлтгэгдсэн ХОА-наар дамжуулан байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд татан оролцуулах, нийгмийн сүлжээг ашиглах гэх мэт аргаар олон нийтдээ мэдээлэл түгээж хүрч ажилладаг.
- ЭБЭ олон нийтийн СДЗШ-нд хамрагдалт болон шинээр оношилогдсон ХДХВ-ийн тохиолдол 2010-2017

	2010	2011	2012	2013	2014	2015
СДЗШ-нд хамрагдсан тоо	340	290	314	350	370	711
Илэрсэн ХДХВ-ийн тохиолдол	7	4	6	1	7	2

Саад бэрхшээл

- Зорилтот тоо өндөр байгаа. (тооцоолол үндэсний хэмжээний тоо 3.400)

- ЭБЭ –гийн дундах тэмбүүгийн халдвар өсөх хандлагатай
- Зөвхөн УБ, Дархан хотуудад үйл ажиллагаа явуулж байгаа.
- Нийгмийн ялгаварлан гадуурхалт өндөр байсаар байгаа.
- Салбарын яамны дэмжлэг, уялдаа хамтын ажиллагаа сул байсаар байгаа.

Цаашид авах арга хэмжээ

- ЭБЭ олон нийтийн эерэг, эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэхэд түлхүү анхаарах. (Нуугдмал, хүрэх боломжгүй хүмүүсрүү чиглэх нь илүү хүч, хөрөнгө шаарддаг.)
- Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон хувийн хэвшлийн бодит оролцоог бий болгох, хамтын ажиллагааг хөгжүүлэх. (ЭБЭ олон нийт рүү, эрсдэлт бүлэг хүн амруу чиглэсэн үйл ажиллагааг тасралтгүй, явуулахад бодлого бий болох, санхүүгийн дэмжлэгийг төрөөс дэмжих.)
- Нуугдмал, ТББ хүрэх боломжгүй ЭБЭ, ТЖ хүмүүст шинжилгээний шинэлэг аргуудыг турших, хэрэгжүүлэх.
- ХДХВ- ээс хамааралтай ялгаварлан гадуурхалтыг байхгүй болгох, хүний эрхийг дэмжих, эрүүл мэнд, эрхийн ээлтэй орчинг бий болгох.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

УАБЗ	<p>Ж.Мөнхжаргал: Надад илтгэл тавьсан байгууллагуудаас асуух 3 асуулт байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүрьеэгийн хоолтой эмчилгээ нь Төрөөс олгогддог хоол хүнсний тусламжтай давхцдаг уу? Хэрхэн уялдуулан ажилладаг вэ? 2. Саяхан ЦЕГ-аас ЧД-т илрүүлэг хийж 400 ЭБҮ илрүүлсэн бөгөөд тэдгээрээс 92% нь БЗДХ-тай, 82% -тай тэмбүүтэй байсан нь үнэхээр бэрхшээл. Энэ талаар мэдээлэл өгнө үү. 3. Асуудал бэрхшээл гэдэгт яагаад ЗГ-ын үйл ажиллагаа, хамтын ажиллагааны асуудлыг дурдаад байгаагаа тайлбарлана уу.
ГС	<p>Аллан НФамба: Цаашид хүрч очих ажилтнуудын үйл ажиллагаа тогтвортой хэрэгжээд явна гэж найдаж байна. ГС-ийн зүгээс төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хэрхэн туслах вэ? Бид саад бэрхшээлд дурдагдаад байгаа энэхүү асуудлыг шийдвэрлэх талаар ямар дэмжлэг үзүүлэх вэ?</p>
АШИУУС	<p>Р.Оюунгэрэл: Монгол улсад олон жилийн турш туслалцаа, дэмжлэг үзүүлж байгаа Олон улсын байгууллагууд ГС, ДЭМБ-д баярлалаа. Та бүхнээс дараах асуултуудыг асууя. МСТН-ээс</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүрьеэгийн үйлчилгээг 8 аймаг, 6 дүүрэгт үзүүлдэг юм байна. Бусад аймаг, дүүргүүдэд тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлдэг вэ? 2. Сургагч багш ЛИСА-ын тусламжтай бэлтгэдэг үү. 3. Сүрьеэгээр өвдсөн үед гар урлалд сурч худалдаалах ЗГ, ОУБ жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн талаар мэдээллэнэ үү. Төгс Бүсгүйчүүдээс асуухад 4. Илрүүлгийн талаар болон, ЕБС-ийн нийгмийн ажилтанг хэрхэн бэлтгэж 5. Бэлгэвчний хэрэглээний асуудал болон бэлгэвчний хангамж хэр вэ? Д.Мягмардоржоос асуухад, 6. ЭБЭ-ийн 76% бэлгэвч хэрэглэдэггүй гэсэн мэдээлэл байна. Энэ талаар тайлбарлана уу? 7. ЭБЭ олоны нийтийн зан үйлийг өөрчлөх сургалт, тохиолдлын бэлгийн хавьталд орох зэрэгт үүрэг хариуцлагыг ухамсарт нь тусгах шашны байгууллагаар суртал ухуулга суулгах талаар ямар боломж байна вэ?
ХОН	<p>Н.Туяацэцэг: Хоолтой эмчилгээ үйлчилгээг Сүрьеэгийн эмчилгээнээс яагаад хассан талаарх мэдээллийг өгнө үү.</p>

Хариулт:

Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг, Б.Солонго дараах хариултуудыг өглөө.

1. Дүүргийн хүнсний тусламж 1,2-р бүлгийн эмзэг бүлгийн хүмүүст хүрдэг. Хэсгийн ахлагч нь тэдгээр хүмүүсийг тодорхойлдог. Тиймээс тэр нь бодит бус байх зэрэг асуудалтай байдаг.
2. 8 аймаг 6 дүүрэгт үйл ажиллагааг холбон Эрүүл мэндийн болон Эрүүл мэндийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг. Жишээлбэл: Кемпински Хаан Палас зочид буудалтай хамтран сар бүр 13 хүнд хоол хүнсний туслалцаа үзүүлээд явж байна.
3. “Амгалан” ТББ-тай хамтран амьжиргаа дээшлүүлэх сургалт зохион байгуулж байна.
4. Сургагч багш нар, нийгмийн ажилтан багш нартай ойр хамтран ажиллаж байгаа ба сургагдсан хүмүүс тодорхой хугацааны дараа төгсөөд үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явдаг. Гар урлал хийж

борлуулах тал дээр хараахан оролцоогүй байна.

5. Хоолтой эмчилгээний зардал өндөр тусдаг болохоор энэ шинэ төслийн үйл ажиллагааны хүрээнд хасаад хүнсний тусламж гэдэг байдлаар оруулсан.
6. ГС-д төслийн үр шим, Төр засгийн оролцоо чухал. Хэрэгжүүлэгч ТБ-ын зүгээс үнэлгээ хийж ажиллах ТБ-г үйл ажиллагаанд илүү оролцуулах тал дээр анхаарах хэрэгэй санагддаг.

Төгс бүсгүйчүүд ТББ-ын талаарх асуултын хариултыг Д.Ням-Өлзий өглөө.

1. Нийслэлийн ЦЕГ-тай 2015 оноос хамтран ажиллаж байна. Ерөнхийдөө ЭБҮ-г торгоод 14-30 хоногийн хугацаанд баривчилдаг. Манай байгууллагаас 2018 оны 9 сарын 10-нд БЗД –д 4 охинтой шөнийн 23-03 цагийн хооронд, 2018 оны 9 сарын 21-нд СХД-д 9 эмэгтэйтэй хамт 23-04 цагийн хооронд хамт явж шөнийн эргүүлд явсан. Харин нэг дүүргээс 300-400 хүн бариад тэдний 80% нь БЗДХ-тай байсан гэдэгт эргэлзэж байна.
2. ЭБҮ-д хүний эрхээ хангуулах бололцоо ерөөсөө байдаггүй.
3. ЕБС-ийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллахгүй. Бид ЕБС-д биш бар, буудал, саунд байгаа ЭБҮ-тэй ажилладаг. Тиймээс ЕБС-ийн талаарх мэдээлэл өгөх боломжгүй.
4. ЭБҮ олон нийт бар, буудал, саунд ажилладаг болохоор бэлгэвчээр тасардаггүй.
5. Манайх 2008 оноос Дэд СХА-аар ажиллаж байна. Түрээс төлж ажиллах байраа бэлтгэж байгаа нь хүндрэлтэй байдаг. Цаашид ЭМЯ-д нөлөөлөл үзүүлэн жижиг ч болтугай байртай болоход тусална уу. Түүнчлэн та бүхэндээ 9 аймаг болон УБ хотын олон нийтээ төлөөлөн талархал илэрхийлж байна.

Залуус эрүүл мэнд ТББ-аас асуусан асуултанд Д.Мягмардорж хариуллаа.

1. Төр засаг, ЭМЯ бидэнтэй хамтран ажиллавал энэ асуудал үүсэхгүй. Тэд хамтран ажиллахгүй байгаа болохоор л хамтын ажиллагаа асуудалтай гээд байна.
2. Нийгэмд зөв мэдлэг мэдээлэл түгээн, зөв хандлага өгч хүний эрхийг хангах хэрэгтэй. Цаашид МУ-д ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль боловсруулах хэрэгтэй. Анх энэ талаар 2011 онд ярьж байсан ч өдийг хүртэл хэрэгжихгүй байна. Тиймээс энэ талаар бодлого боловсруулан нийгмийн хандлагыг өөрчлөх нь зүйтэй.
3. Төр засгийн зүгээс бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллахгүй байхад бидэнд 10 гаруй жил тусалсан ГС цаашдын хамтын ажиллагааг хэрхэн өргөжүүлэхэд туслах вэ? Гэж байгаа нь ичгэвтэр санагдаж байна. Энэ талаар удирдамж боловсруулан цаашид хамтран ажиллах хэрэгтэй.
4. Бэлгэвчний хэрэглээний талаар ЗГ анхаарах хэрэгтэй. Аливаа буудлуудад 3 ширхэг бэлгэвч л байдаг тэгэхээр 2 эрэгтэй хүн тэнд ороод тэрнээс яагаад ч хэрэглэхгүй, тоолох бололцоогүй 1-г аваад хэрэглэхэд мэдэгдэхгүй байх байдлаар тоог нь олшруулах талаар буудлуудаа шахах хэрэгтэй.

Б.Мягмар: Төрийн хүрч очиж чадахгүй байгаа газарт манай ТББ болон СХА–чид сайн хүрч очдог. Сүрьеэтэй олон нийт болон ЭБЭ, ЭБҮ-д та бүхэн маань л хүрч очин хүнд хэцүү ажлыг нугалж байна. Тиймээс бид асуудлыг хайх биш хэрхэн дэмжих талаар бодолцох хэрэгтэй. ЭМЯ-ны мэргэжилтэн Д.Ганзориг энэ хуралд хүрэлцэн ирсэн тул зохих албан тушаалтнуудад эдгээр саналуудыг уламжлан илтгэж өгнө үү. Түүнчлэн ГС-ын төлөөллүүддээ Монгол улсын төлөө цаг заваа зарцуулан бидний төлөө бидний мэдэхгүй байгаа зүйлсийг ч мэдэж анхааран ажиллаж байгаад нь талархаж байна.

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х				
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх		
			Нууц санал хураалт		
		Дэмжсэн>			
		Эсрэг>			
		Санал өгөхөөс түдгэлзэх			

Хөтөлбөр #5

Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ/ДОХ-ын олон орны хамтарсан төслийн эхийг танилцуулах, Асуулт, хариулт

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Австралийн ДОХ-ын Холбооны зөвлөх **Жозелин Пан** ХДХВ-ийн эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн олон орны хамтарсан төслийн эхийг танилцуулахаар хүрэлцэн ирсэнээ нийт хуралд оролцогчдод илэрхийлэв. */Хавсралт 4- Эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ/ДОХ-ын олон орны хамтарсан төслийн эх /* 2018 оны 2-р сард гол сонирхогч талуудын оролцоонд үндэслэн Ази тив дэх олон улсад Глобал сангийн тэтгэлгийг Папуа Шинэ Гвиней, Зүүн Тимор, Малайз, Филиппин, Лаос, Монгол, Бутан, Шри-Ланк зэрэг 8 оронд зарцуулах удирдамжийг боловсруулан ажиллаж байна.

Энэхүү тэтгэлэг нь Азийн бүсийн орнуудад ХДХВ-ийн халдвар авах өндөр эрсдэлтэй голлох хүн ам болон биеэ үнэлэгч, эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд, трансжэндэр, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүсд тогтвортой үйлчилгээ үзүүлэхийг зориход оршино. Энэхүү буцалтгүй тусламж Глобал сангийн дэмжлэгтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй улс орон болон олон улсын хэмжээнд олгогдон, тухайн бүс нутгийн хүн амд шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэх болон урт хугацааны санхүүжилтийг нэмэгдүүлэх стратегийг боловсруулах зорилгод улс орон бүр анхаарлаа төвлөрүүлэхдээ:

- Голлох хүн амын тоо, хөтөлбөрийн хамрах хүрээ, гол хүн амын хэрэгцээг үнэлэх зэрэг эпидемиологийн болон хариу үйлдлийн хамгийн сүүлийн үеийн стратегийн мэдээллүүдээр хангах;
- Голлох хүн амд хүрч үйлчлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлж, үйлчилгээний үе шатыг хадгалах;
- Олон нийтийн хариу арга хэмжээ, чадавхийг бэхжүүлж түлхүүр хүн амд зориулсан үйлчилгээг өргөжүүлэхийг дэмжих тогтолцоог сайжруулах;
- Олон нийтэд түшиглэсэн судалгаа, мэдээллийн болон бусад стратегийн мэдээллийг үр дүнтэй ашиглах, олон нийтийг идэвхжүүлэх замаар олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ үзүүлэх тогтвортой байдлыг хангахад орон нутгийн нөлөөллийг бэхжүүлэх;
- Холбогдох тохиолдолд гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах болон бусад хүний эрх, жендэртэй холбоотой бэрхшээлийг шийдвэрлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх;
- Дотоодын хөрөнгө оруулалт, зарцуулалтыг баталгаажуулах замаар үндэсний түвшинд үйлчилгээг хүргэх урт хугацааны тогтвортой байдлыг хангах, шинэлэг хандлагыг судалж, гол хөтөлбөрүүдийн санхүүжилтийн өөр эх үүсвэрийг тодорхойлох.

2018 оны 3-р сараас 4-р сарын хооронд Глобал сангийн Ажлын Алба нь бүс нутгийн байгууллагуудаас бүсийн яриа хэлэлцээр явуулахыг уриалсан. Үүний үр дүнд, Глобал сангийн санхүүжилтийн хүсэлтийг 2018 оны 8-р сарын 6-нд хүргүүлэх зорилгоор Австралийн ДОХ-ын нэгдсэн холбоо (цаашид “АFAO” гэх) энэхүү үүргийг гүйцэтгэхээр сонгогдсон.

Олон улсын тусламж авах улс орнууд (Бутан, Лаос, Малайз, Монгол, Папуа Шинэ Гвиней, Филиппин, Шри Ланка, Тимор-Лена) 3 жилийн хугацаанд 12.5 сая ам.долларын буцалтгүй тусламж (2019-2021 он)

- Бүс нутгийн болон улс орны үйл ажиллагаа
- Нөлөөлөл болон тогтвортой байдалд анхаарлаа хандуулах
- Түлхүүр хүн амын сүлжээ болон олон нийт, түншүүдийн үүрэг хариуцлагыг сайжруулах
- Засгийн газар болон бусад салбаруудтай түншлэх, үндэсний стратегитэй уялдуулах
- **Монгол улсад нийт 945,815 ам.доллар олгохоор хуваарилсан.**


Монгол улсын тэргүүлэх үйл ажиллагаа

Үйл ажиллагаа	Төсөв (ам.доллар)
ХДХВ-ийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх	92,344
ТЖ найрсаг үйлчилгээ хөгжүүлэх/дэмжих:	36,055.00
Олон нийттэй харилцах ээлтэй эмнэлэгүүдийг дүүрэг, аймгийн түвшинд сонгох.	44,337.36
ДОХ-ын дотоодын санхүүжилтийг нэмэгдүүлэх:	57,729.00
Стратеги мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх	6,620.51
Олон нийтийн зураглалын судалгаа хийх	30,000.00
Түлхүүр хүн амын эрүүл мэндийн болон нийгмийн шударга ёсны харилцаанд тулгарч буй асуудлыг арилгах стратеги мэдээлэл	120,000.00
Түлхүүр хүн ам болон ХДХВ-ийн халдвартай хүмүүсийг шинжлэх, эмчлэхэд саад учруулах бүхий л эрх зүйн саад бэрхшээлийг арилгахад эрх зүйн дэмжлэг үзүүлэх	72,998.00
Түлхүүр хүн амын хөтөлбөр, бодлогын нөлөөлөл, үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх зорилгоор ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх Үндэсний ХДХВ/ДОХ-ын шүхэр байгууллага байгуулах	126,398.58

Улс орны түвшинд хэрэгжүүлж буй босоо үйл ажиллагаа

Үйл ажиллагаа	Төсөв (ам.доллар)
САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ Улс орны санхүүжилтийн төлөвлөгөө	131,250
СТРАТЕГИ МЭДЭЭЛЭЛ Олон нийтэд түшиглэсэн мэдлэг, хандлага, зан үйлийг хянах, үйлчилгээний чанарын хяналтын загварыг боловсруулан туршиж үзэх, сургалт явуулах	18,600
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эмчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, өргөжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах (нэмэлт арга хэмжээ авахын тулд 2-р шатны буцалтгүй тусламж олгох хамгийн бага хувийг хуваарилах)	18,600
ОЛОН НИЙТИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ CSS-ийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг дэмжих	25,957
ОРЧИН НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ APN+ -ээр удирдуулан Ази, Номхон далайн орнуудын эрүүл мэндийн хөтөлбөрт бүс нутгийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх замаар Азийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцад гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах явдлыг бууруулах –	9,300
ХОЁР ДАХЬ ШАТНЫ ХӨТӨЛБӨР	80,347

СХА сонгон шалгаруулах үйл явц



Дараагийн алхмууд

- Төлөвлөсөн үйл ажиллагааны төлөвлөгөөг улс орон, бүс нутгийн түвшинд эцэслэн боловсруулах: Зөвлөлдөх
- Үр дүнтэй арга хэмжээ авах
- ҮЗЗ-ийн танилцуулга ба батламж: 11 дүгээр сарын 6
- Глобал сангийн дэмжлэгтэй төсөл хөтөлбөрийн баримтыг бүрдүүлж дуусгах: 11 дүгээр сарын 6
- Техникийн хяналтын хорооны зөвлөмжийн тойм: 11 дүгээр сарын 20
- СХА-ийг сонгох : 11-р сарын 26
- ҮХА-ийн ажилтнуудын сонголтыг эцэслэх: 12-р сарын 1
- **Төсөл хэрэгжиж эхлэх : 2019 оны 1 дүгээр сарын 1**

Улс орны авах арга хэмжээ

- Улс орны үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг эцэслэх
- ҮЗЗ-ийн батламж
- Улс орны зохицуулах бүтцийг байгуулах
- Улс орны ҮЗЗ болон үндэсний стратегийн байгууллагуудын уялдаа холбоог тогтоох, (төлөвлөлт, уялдаа холбоо, харилцаа, хурлын гэмдэглэлүүд)

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

МҮЭ	<p>Б.Мягмар: Олон улсын зөвлөхийн санал дээр нэмэх санал ХЗН-д байна уу? Олон улсын зөвлөхөөс асуух хэдэн асуулт байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. ҮЗЗ-ийн зүгээс энэхүү төслийг батламжилсан шийдвэрийг хэзээ гаргах хэрэгтэй вэ? 2. ҮХА-аар ЭМЯ ажиллах уу? 3. ДОХ-ын Шүхэр байгууллагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү. <p>Бид эдгээр хөтөлбөрүүдийн тогтвортой байдлыг ханган хамтран ажиллаж дараа дараагийн жилүүдэд төсөвт тусгах хэрэгтэй гэдгийг анхааруулан одоо хүлээн авах 945,000 ам.долларын санхүүжилтыг үр ашигтай зарцуулахыг сануулж байна. Түүнчлэн энд хүрэлцэн ирж 7 хоногийн турш бидэнтэй хамтран ажилласан бүсийн төлөөллүүдэд дахин талархал илэрхийлье. Цаашид ҮЗЗ-ийн зүгээс хичээн ажиллаж шаардлагатай албан бичгийг дариу төлөвлөн ЭМЯ-д хүргүүлэн асуудлыг хурдан шуурхай шийдэж хамтран ажиллаж байх болно.</p>
-----	---

ГС	<p>Лука Очини: Та бүхнийг биднийг хүлээн авч хуралд оролцуулсанд баярлалаа. Цаашид та бүхэн тогтвортой байдал, тэгшитгэл, санхүүжилтдээ анхаарлаа хандуулан олон нийтийнхээ оролцоог сайжруулан Төр болон иргэний нийгмийн байгууллагынхаа хамтын ажиллагааг уялдуулан нэгдсэн үр ашигтай үр дүнд хүрэх нь чухал гэдгийг хэлэх байна. Баярлалаа.</p>
----	---

Хариулт:

Жозелин Панг:

1. ҮЗЗ-ийн батламжийг 2018 оны 11 сарын 6-нд хүлээн авах шаардлагатай. Тухайн үед та бүхний саналыг аль нэг замаар авах эсэхээ шийдвэрлэн и-мэйл хүргүүлэх болно. Тэгэхдээ төслийн талаарх бүхий л мэдээллийг нарийн тайлбарлан хүргүүлнэ.
2. Энэхүү олон улсын төслийн ҮХА-аар Австралийн ДОХ-ын Холбоо ажиллах болно. Тэндээс СХА-гаа нээлттэй сонгон шалгаруулж ажиллана.
3. Шүхэр байгууллагын хувьд ТББ болон ТБ-ын уялдаа холбоог сайжруулан, олон нийтийн дуу хоолойг хүргэх зорилгоор байгуулагдан ажиллах бөгөөд энэ талаар 7 сараас хойш зохион байгуулагдсан 2-3 уулзалтууд дээр бодлогын баримт бичгээ боловсруулаад явж байна. Үүнд ҮЗЗ-ийн гишүүд болон хамтрагч талуудын төлөөллүүд оролцож байгаа ба цаашид ч хамтран ажиллана.

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх
			Нууц санал хураалт
		Дэмжсэн>	
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#2			


хөтөлбөр#4			
------------	--	--	--


ДАРААГИЙН ХУРАЛ (ОГНОО, ХӨТӨЛБӨР)			
Огноо	2018 оны 12 дугаар сар		
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр		

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	

БЭЛТГЭЛ АЖИЛ (Тохирох нүдийг бөглөнө үү			
	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон оролж ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:	
Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЗГ	Засгийн Газар
СЯ	Сангийн Яам
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТНБД	Төрийн Нарийн Бичгийн Дарга
ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ЭМ	Эрүүл Мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ҮХА	Үндсэн Хүлээн Авагч
СХА	Салбар Хүлээн Авагч

БАТАЛСАН:			
Нэр>	Б.Мягмар	DATE >	2018 оны 10 сарын 20
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	

ХЯНАСАН:			
Нэр>	Б.Оюундарь	Огноо>	2018 оны 10 сарын 20
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:			
Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2018 оны 10 сарын 20
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	